



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 5 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар  
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт  
оруулах тухай

Концессын тухай хуулийн 6.1.1, 10.1, 17.1.1, Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 35/32 дугаар зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 07/04 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ын 10 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 53<sup>3</sup> дахь заалт нэмсүгэй:

№	Концессын зүйлийн нэр	Концессын зүйлийн тодорхойлолт	Концессын төрөл	Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ	Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх	Уралдаант шалгаруулалт явуулах, шууд гэрээ байгуулах эсэх
53 <sup>3</sup>	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам төсөл	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьж, концессын гэрээний хугацаанд ашиглан гэрээний хугацаа дуусгавар болоход төрд шилжүүлэх	Зураг төсөл боловсруулах -барих-ашиглах-шилжүүлэх	Тавантолгой орд газраас-Дорноговь аймгийн Зүүнбаян сум хүртэл 414 км төмөр зам барих, ашиглах	Шаардлагагүй	Шууд гэрээ байгуулах

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам төсөл"-ийн концессын гэрээний хэлэлцээр хийх үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, гэрээний хэлэлцээрийг хийж, дүнг гэрээний төслийн хамт зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд даалгасгай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга

У.ХҮРЭЛСҮХ

Г.ЗАНДАНШАТАР